



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯМНЫ ХАРЬЯА
**БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, <http://www.ltpd.mn>

2019.07.09 № 1/202
танаи _____ -ны № _____ -т

Г Онол практикийн бага хурлын
удирдамж хүргүүлж, бэлтгэл
хангуулах тухай

Жил бүр "ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ" сэдэвт онол практикийн бага хурлыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран зохион байгуулдаг билээ. 2019-2020 оны хичээлийн жилд VII бага хурлыг 2019 оны 11 дүгээр сарын дөрөвдүгээр долоо хоногт (Хугацааг жич зарлана) зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлж байгаа бөгөөд та бүхэн сургуулиудад уламжилж, удирдах ажилтан, багш нарыг хуралд чанартай илтгэл бэлтгэж, бүтээлчээр оролцуулахад дэмжлэг үзүүлнэ үү.

Хавсралт "ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ" сэдэвт онол практикийн VII бага хурлын удирдамж 7 хуудастай.

ЗАХИРАЛ

Ж.БОЛОРМАА



БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ЗАХИРАЛ

БАТЛАВ.



Ж.БОЛОРМАА

“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ”
УХДО СЭДЭВТ ОНОЛ ПРАКТИКИЙН VII БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

БАТЛАВ ААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ОЮУНЦЭЦЭГ
НИЙГЭМЛЭГ
ПУТЬ

Н 38944 № 8118477

ТАНИЛЦУУЛГА

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран 2013 оноос хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах шинэлэг арга зүй, туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх зорилгоор онол практикийн бага хурлыг зохион байгуулж ирсэн.

Боловсролын талаар төрөөс баримталж буй бодлого, Багшийн хөгжил хөтөлбөр, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2030 он), Монголын багш нарын VII их хурлын шийдвэр, 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтын хэрэгжилтийг дэмжихэд онол практикийн VII бага хурлын үйл ажиллагаа чиглэгдэж байна.

Уламжлал болсон онол практикийн бага хурал нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлж, улмаар багш нар ажлын байрандаа хамтдаа тасралтгүй хөгжих нэг арга хэрэгсэл болж байгаа төдийгүй уралдаан, өрсөлдөөн бус хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн асуудлаар харилцан туршлага солилцох, тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэж, багшлахуйн болон суралцахуйн чанарыг сайжруулах чиглэлээр нэгдсэн шийдэлд хүрэх ажлын байран дээр мэргэжлээ дээшлүүлэх талбар болдог.

Чиглэл:

“Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт тавдугаар онол практикийн бага хурал нь “Боловсролын чанар нь хичээлийн чанараас, хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас” гэсэн уриан дор дараах чиглэлийн хүрээнд зохион байгуулагдана.

- Сургуульд сууринсан хичээлийн судалгаа: Сургуулийн эрхэм зорилго, зорилтыг болон тулгамдсан тодорхой асуудлыг шийдэх, хэрэгжүүлэх үүднээс сургуулийн хичээлийн судалгааны багийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүн, арга туршлагыг илтгэнэ.
- Судлаадахуунд сууринсан хичээлийн судалгаа: Тодорхой судлагдахуунаар хичээлийн судалгааны арга зүйг хэрэгжүүлсний үр дүнд багшлах болон суралцах шинэ арга туршлага, арга зүй, хичээлийн технологи боловсруулан туршсан судалгаа, үр дүнг илтгэнэ.
- Хүүхдийн хөгжлийн судалгаа: Хүүхдийн хөгжлийн тулгамдсан асуудлыг үндэслэлтэй илрүүлэн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж тэдгээрийг шийдэх

арга замыг дэвшүүлэн туршиж хүүхдийн харилцаа, хандлага, төлөвшилд ахиц өөрчлөлт гаргасан болон үнэлгээний чиглэлээр дэвшүүлсэн шинэлэг арга зүй, туршлага, үр дүнг илтгэнэ.

- Тусгай хэрэгцээт боловсролын судалгаа: Тусгай хэрэгцээт, тэгш хамруулан сургах, хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн боловсролын чанарыг сайжруулах чиглэлээр хийж буй судалгаа, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, туршлага, үр дүнг илтгэнэ.

Сургуулийн өмнөх боловсролоос дээд боловсролын түвшин хүртэлх судалгаа хамрагдана. Судалгааны цар хүрээ, арга, аргачлал, хүрсэн үр дүн зэргээс хамаарч илтгэлийг үндсэн, аман, ханын, хэлэлцүүлэгт (workshop) илтгэл гэсэн 4 хэлбэрээр хэлэлцэнэ.

- Үндсэн илтгэл: Багшах арга зүй, хичээлийн судалгааны чиглэлээр шинэлэг санаа дэвшүүлсэн, тулгамдаж байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, цаашдын хөгжлийн чиг хандлагыг илэрхийлсэн судлаачдын илтгэл байна.
- Хэлэлцүүлэгт илтгэл (Workshop): Багшах арга зүй, хичээлийн судалгааны чиглэлээр тулгамдсан асуудлыг хамтран шийдэж, түгээн дэлгэрүүлэх шинэлэг арга замуудыг санал болгосон судалгааны үр дүнг хэлэлцүүлэнэ.
- Салбар хуралдааны илтгэл: Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааны чиглэлээр хийж байгаа судалгааны ажил, практикт туршиж, хэрэгжүүлсэн шинэлэг, бүтээлч арга туршлагыг онол практикийн бага хурлын 3-4 чиглэлээр хэлэлцэнэ.
- Ханын илтгэл: Судалгааны үр дүнг хэвлэмэл байдлаар бэлтгэсэн аль ч чиглэлийн илтгэлийг хэлэлцэнэ.

ХУРЛЫН ЗОРИЛГО

Онол практикийн бага хурлын зорилго нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшах шинэлэг арга зүй, туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхэд оршино.

ОРОЛЦОГЧИД

1. СӨБ болон ЕБС-ийн багш, удирдлага
2. Нийслэлийн болон орон нутгийн БСУГ-ын мэргэжилтэн
3. Боловсролын салбарын мэргэжлийн байгууллагын арга зүйч, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан
4. Их дээд сургуулийн багш, судлаач, оюутан

ИЛТГЭЛ ХҮЛЭЭЖ АВАХ, ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА.

Зохион байгуулах: 2019 оны 11 дүгээр сарын гуравдугаар долоо хоногт, Улаанбаатар хотод Багшийн хөгжлийн ордонд зохион байгуулна.

Илтгэл хүлээж авах: Илтгэлийн хураангуй болон дэлгэрэнгүйг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 18 цаг хүртэл файл хэлбэрээр hicheeliin.sudalqaa2014@gmail.com хаягаар цахим (хаяг: mals.mn сайтын ИЛТГЭЛ ХҮЛЭЭН АВАХ)-аар хүлээн авна. Хуралд ирүүлсэн илтгэлийн тоогоор хураамж төлнө. Илтгэлийн хураамжийг Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн голомт банкны 1410013273 тоот дансанд шилжүүлж, баримтыг илтгэлийн хамт илгээнэ (Үндсэн болон салбар хуралдааны илтгэл 25000 төгрөг, ханын илтгэл – 20000 төгрөг, илтгэгчээс бусад оролцогч 10000).

Илтгэлийг хэлэлцэх: Илтгэлийг хоёр үе шаттай хэлэлцэнэ.

1-р үе шат: Мэргэжлийн комисс тодорхой шалгуурын дагуу ирүүлсэн илтгэлүүдийг уншиж, онол практикийн бага хуралд хэлэлцэх илтгэлийг сонгоно.

2-р үе шат: Онол практикийн бага хуралд сонгогдсон илтгэлийг хэлэлцүүлнэ.

Шалгаруулалт, урамшуулал: Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах шинэлэг арга зүй, туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхэд үр нөлөө бүхий гурван илтгэлийг урамшуулна. Үүнд:

- Батламж, “Япон улсад хичээлийн судалгааны туршлага судлах сургалт”-д оролцох эрх
- Батламж, “Солонгос, Монголын багш солилцооны хөтөлбөр”-т хамрагдах нэг эрх
- Батламж, “Орос, Монголын багш солилцооны хөтөлбөр”-т хамрагдах нэг эрх

БУСАД

Онол практикийн хуралд оролцогчдын томилолт болон замын зардлыг орон нутаг, сургууль хариуцна. Аймаг, нийслэлийн БСҮГ нь хуралд оролцох багийг зохион байгуулж, оролцено.

ИЛТГЭЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА

Өмнөх жилүүдэд зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжил-Хичээлийн судалгаа” сэдэвт бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийг, хичээлийн судалгааны илтгэл бичих зөвлөмж, илтгэлийн бүтэц, жишээг www.itpd.mn, www.mals.mn сайтаас харна уу.

1. Сургуулийн удирдлагын хэлэлцүүлэх илтгэлийн бүтэц-Сургуульд суурилсан хичээлийн судалгаа (сургуулийн түвшинд):

ИЛТГЭЛИЙН НЭР:

Илтгэгч: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-майл хаяг

Илтгэлийг хамтран боловсруулсан багийн гишүүд: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-майл хаяг

ХУРААНГУЙ

- Зорилго
- Судалгааны загвар /арга зүй/ хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг
- Товч агуулга: 200-250 үг

ИЛТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Удиртгал

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Сонгосон судлагдахуун
- Хамрах хүрээ: Хэддүгээр ангийн хэдэн сурагчид хамрагдсан болох, ямар мэргэжлийн хэдэн багш хамрагдсан болох
- Эзэрэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

Хугацаа:

- Энэхүү судалгааг ямар хугацаанд хийсэн болох

Хэрэгжүүлсэн байдал

- Гол үйл ажиллагаа /Товч: Сурагчдыг хэрхэн хөгжүүлсэн болох, багшийн арга зүй хэрхэн сайжирсан болох, бие биенээсээ хэрхэн суралцсан болох/

Судалгааны үр дүн

- Зорилгодоо хүрсэн байдал: Дээрх үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж чадсан эсэхийг нэгтгэн дүгнэх, үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх
- Яагаад сайн болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Цаашид хөгжүүлэх санал

Ном зүй

Судлагдахуунд суурилсан **ЕБ-ЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ИЛТГЭЛИЙН БҮТЭЦ**
(тодорхой хичээлээр):

СУДЛАГДАХУУН:

ИЛТГЭЛИЙН НЭР:

Илтгэгч: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-майл хаяг

Илтгэлийг хамтран боловсруулсан багийн гишүүд: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-майл хаяг

ХУРААНГУЙ

- Зорилго
- Судалгааны загвар /арга зүй/ хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг
- Товч агуулга: 200-250 үг

ИЛТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Удиртгал

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Хичээлийн санаа
- Хичээлийн бэлтгэл судалгаа
- Судалгаат хичээл

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл (мэдлэг бүтээлгэх)

- Хүүхдээр юуг, яаж нээлгэсэн тухай алхмууд (Таамаглал дэвшүүлэх, таамаглалаа шалгах, турших, хэлэлцэх гэх мэт)
- Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

Судалгааны үр дүн

- Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт
- Судалгаат хичээлийн төлөвлөлтийн өрөнхий санаа: Багшийн асуулт-үндсэн үйл ажиллагаа, тухайн хэсгийн шийдэл-гол санаа
- Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал: Хичээлийн үеийн протоколын хэсгээс ишлэл хийж, тайлбарлах байдлаар хичээлийн төлөвлөлтийг /хичээлийн эхлэл, өрнөл, төгсгөл /хэрэгжүүлсэн байдлыг танилцуулна.

Дүгнэлт:

- Яагаад сайн хичээл болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Бусад

Ном зүй

2. Судлаачдын илтгэлийн бүтэц

- Гарчиг 12pt том үсгээр эхэлж жижиг үсгээр бичнэ.
 - Зохиогчдын нэр, байгууллага, хаяг, 9pt, налуу, том үсгээр эхэлнэ.
- Товч утга (монгол хэл дээр бичих)
- Түлхүүр үг (заавал биш)
- Удиртгал
- Үндсэн хэсэг
 - Онолын арга зүй
 - Туршилт судалгааны хэсэг
- Үр дүн, дүгнэлт
 - Талархал
 - Ишлэл буюу ном зүй

ИЛТГЭЛИЙН БИЧВЭР, ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТЭД ТАВИХ ШААРДЛАГА

1. Цаасны хэмжээ ба зайд авах

- Цаасны хэмжээ A4 байх.
- Бичиглэл дээд талаасаа 2.5 см, доод талаасаа 2.5 см, зүүн талаасаа 3 см, баруун талаасаа 1.5 см, мөр хоорондын зайд 1.15 см байх.

2. Хэл

Өгүүллийг MS word программ дээр "Times new roman" фонт ашиглан үсгийн өндөр 10pt-ээр монгол хэл дээр бичнэ. Илтгэлийн хураангуйг монгол хэл дээр "Times new roman" фонт ашиглан бичнэ.

3. Илтгэлийн бичиглэлд тавигдах шаардлага

- Ишлэлийг дөрвөлжин хаалтанд [зохиогчийн нэр, он] загвараар хийнэ.
- Тооны аравт, зуутын орны таслалыг цэгээр тэмдэглэнэ.
- Томьёог налуугаар бичнэ.
- Зохиогчдын нэр, байгууллага, хаяг нь том үсгээр эхэлж, үсэг нь 9pt-ийн өндөртэй, налуугаар бичнэ. Мөн илтгэлийн хураангуйг 9pt-ийн өндөртэй бичнэ.
- Товч утга нь 200-250 үтгэй байна.
- Илтгэлийн дэлгэрэнгүйн үсэг нь 11pt-ийн өндөртэй, мөр хоорондын зайд 1,15 см байна.
- Ишлэлийн үсгийн өндөр нь 10pt байна. Ишлэлийг Microsoft Word программын reference цэсний insert footnote ашиглан хийнэ.
- Ном зүйг Microsoft Word программын reference цэсний Citation&Bibliography-г ашиглан APA style – аар хийнэ.

Илтгэл №1, №2-ыг дараахи шаардлагын дагуу бэлтгэх.

- Илтгэлийн хураангуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу А4-ийн 2 нүүрээс илүүгүй бэлтгэх
- Илтгэлийн дэлгэрэнгуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу А4-ийн 10-12 нүүрээс илүүгүй бэлтгэх. Хэт олон нүүр илтгэл ирүүлбэл “шаардлага хангаагүй” гэсэн үнэлгээ авч хасагдах болно.
- Илтгэлийн бичвэрийн өмнө нүүр хуудас хийхгүй шууд сэдвээ бичээд эхэлнэ.
- Аман илтгэлийн хугацаа 15 минут байхаар тооцох. Үзүүлэх материалыг MS Power Point, Prezi программын ашиглан бэлтгэх. Сайжруулсан хичээлийн хөтөлбөр, хичээл ажиглалтын хуудас, хэлэлцүүлгийн протокол, фото зураг, видео бичлэг зэрэг баримтуудыг хавсаргаж болно.

Ханын илтгэлийг дараах шаардлагын дагуу бэлтгэх.

- Илтгэлийн хураангуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу 2 нүүрээс илүүгүй бэлтгэх
- Илтгэлийн дэлгэрэнгуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу А4-ийн 10-12 нүүрээс илүүгүй бэлтгэх.
- Илтгэлийг 120 : 80 см хэмжээтэйгээр хэвлүүлнэ.

БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТУХАЙ

1. Онол практикийн бага хурлын өмнө илтгэлийн хураангуй хэвлэгдэнэ.
2. Онол практикийн хурлын дараа бичвэр ба илтгэл тавигдах шаардлага хангасан илтгэлүүдээр хурлын илтгэлийн эмхэтгэлийг гаргаж, цахимаар байрлуулна.
3. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн сайн туршлага бүхий үр нөлөөтэй илтгэлийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын www.itpd.mn веб сайт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн www.mals.mn веб сайтад байршуулна.